

БАТЛАВ:ЗАСАГ ДАРГА



Х.БАТТУЛГА

ЗАХИАЛАГЧ :БАЯН-УУЛ СУМ ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Ахуй үйлчилгээний байр засварлах, төвлөрсөн
халаалтанд холбох "ажлын тендерийн
бичиг баримт

ГЭРЭЭНИЙ ДУГААР - ОНХС/2020/01

2020 он

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 07 сарын 29-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **“Ахуй үйлчилгээний байр засвар үйлчилгээ, төвлөрсөн халаалтанд холбох” ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОНХС/2020/01**

Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГазар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Ахуй үйлчилгээний байрны засвар үйлчилгээ, төвлөрсөн халаалтанд холбох” ажилд** тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерийн материалын үнэ болох 50,000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байх бөгөөд багцгүй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2019 оны борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас багагүй

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн 30%-иас багагүй байх

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оны баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлнэ.

Ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жилд хийгдсэн ижил төстэй ажлын туршлагын талаархи жагсаалт, нотлох баримтууд

Үйл ажиллагааны чиглэл: Модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл / Хагас болон бүтэн боловсруулсан/

Тусгай зөвшөөрөл шаардах эсэх. Тийм

1.Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт /Туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж болно/

2. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер , орчны тохижилт/ Туслан гүйцэтгэгчтэй байж болно./

Тендерийг 2020 оны 8 дүгээр сарын 06-ны өдрийн **14 цаг 30 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 08 дугаар сарын 06 -ны өдрийн 15 цаг 00 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцохгүй Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Дорнод аймаг Баян-Уул сум Бэрх 4-р баг ЗДТГ-ын байр 2 давхар 204 тоот Санхүүгийн алба

Утас: 89118312,88088838

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дээр дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах,эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
	<p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайгаа нотлохын тулд захиалагчид нэмэлт нотлох баримтыг тендерийн бичиг баримт бичигт хавсаргаж ирүүлэх</p> <p>Аж ахуйн нэгжлийн танилцуулга</p> <ol style="list-style-type: none"> 1. .Аж ахуйн нэгжийн товч танилцуулга 2. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан санхүүгийн байгууллагаар баталгаажсан байна. 3. Сүүлийн / 3 буюу 2017-2019 онуудын аль нэг онд ижил төстэй ажил, бараа үйлчилгээр гэрээгээр гүйцэтгэсэн байх /туршлагын мэдээлэл/гэрээгээр гүйцэтгэсэн болон одоо гүйцэтгэж байгаа ажлын гэрээний хуулбар/ 4. Борлуулалтын хэмжээ.Сүүлийн 1 жилийн :борлуулалтын орлогын мөнгөн дүнгийн дундаж нь санал болгож буй нь үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна. <p>Холбогдох байгууллагуудын тодорхойлолт</p> <ol style="list-style-type: none"> 5. Татварын байгууллагын тодорхойлолт /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байна. 6. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /өргүй байна/ 7. Харилцагч банкны байгууллагад хугацаа хэтэрсэн өр зээлгүй, зээлийн батлан даалтаар гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй байна. 8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэн , хуулийн хуулийн этгээдэд өр төлбөргүй тухай тодорхойлолт / эх хувиар/ 9. Шүүхийн байгууллагын тодорхойлолт <p>10.10.Тендерт оролцогч нь тухайн ажилд шаардлагатай дараах зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл / Хагас болон бүтэн боловсруулсан/ 2.Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуурын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт /Туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж болно/ <p>11.Тендерт оролцогч нь ажил гүйцэтгэх дараахь үндсэн тоног төхөөрөмжийг ажил гүйцэтгэх хугацаанд /өөрийн , түрээслэх, хөлслөн авах... гэх мэт/ бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ачааны авто машин механикм болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж <p>12. Үе шатны болон санхүүжилтын хуваарь /Бараа ажил үйлчилгээ нийлүүлэх үе шатны болон санхүүжилтын хуваарийг заасан маягтаар боловсруулан тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх/.</p> <p>13. Түргэн хөрвөх чадварыг тодорхойлсон баримт ирүүлнэ. Үүнд: Барааны үлдэгдэл, харилцах дансны хуулга/үлдэгдэл/, харилцагч банкнаас зээл авах боломжтой зээлжих эрх нь нийт төсөвт өртөгийн 30 хувиас багагүй байна.</p> <p>14. Мэргэжлийн байгууллагаар баталгаажсан төсөвтэй байна. / Захиалагчаас өгсөн ажлын даалгаварт тулгуурлан эдийн засгийн</p>

	<p>үндэслэлийг боловсруулан мэргэжлийн байгууллагаар зураг төсөв боловсруулан баталгаажуулж ирүүлнэ./</p> <p>15. Дээрх нэмэлт материалуудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажаагүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн 3 жилд хийгдсэн ажил нь хангалтгүй байсан нь өмнөх захиалагчийн болон хяналт шалгалтын байгууллагаар нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГазар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГ-ын байр 2 давхар 204 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 8 дугаар сарын 05-ны өдөр]</p> <p>Цаг: 14 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг:Дорнод аймаг Баян-Уул сум ЗДТГазар бэрх 4-р баг</p> <p>Давхар болон өрөөний дугаар: : Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГ-ын байр 2 давхар 204 тоот өрөө</p> <p>Огноо:2020 оны 8 дүдлдь гаар сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 00 минут</p>
ТӨӨЗ.2.3	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлор дараахь баримт бичиг материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл 3. Үнийн саналыг жишиг маягтаар ирүүлнэ
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь :]багцгүй байна/</p> <p>Санхүүгийн эх үүсвэр:</p> <p style="text-align: center;">Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ,25,000,000 төгрөг</p>

**“АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН БАРИЛГЫГ
ЗАСВАРЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Баян-Уул сум

Үндэслэл	Тус сумын ахуйн үйлчилгээний төв нь 2010 онд ОНТХөрөнгө оруулалтаар модон байшин барих уламжлалт аргаар баригдсан бөгөөд энэ хугацаанд засварын ажил
----------	--

	хийгдэж байгаагүй, өрөө тус тус бүр уламжлалт зуухан галлагаатай, ханаар дулаан алдалттай, хаалга, цонхнууд муудсан зэргээс түрээслэгчид хэвийн үйл ажиллагаа явуулах боломж, иргэд тохь тухтай орчинд үйлчилгээ авах боломжгүй зэрэгт дүгнэлт хийж сумын “ОНХС”-ийн 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар хийгдэх шаардлагатай болсон.
Барилга, байгууламжийн байршил, чиглэл	<i>Дорнод аймгийн Баян-Уул сум 4-р багийн нутаг дэвсгэрт “Соёлын төв”-ийн хойд талд</i>
<i>Захиалагч байгууллага:</i>	<i>Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар</i>
<i>Хөрөнгийн эх үүсвэр:</i>	<i>Сумын “ОНХС”-ийн хөрөнгө оруулалт</i>
<i>Зориулалт, хүчин чадал:</i>	<i>Үсчин, гутал засвар, жижиг хэвлэлийн үйлчилгээ, цахилгаан хэрэгслийн засвар зэргийг ажиллуулах 6 өрөө бүхий /17*8м/ нэг давхар модон хийцийн барилга</i>
<i>Архитектур төлөвлөлтөд тавигдах шаардлага</i>	<p><i>Барилгын үндсэн хийцийн засвар:</i></p> <ul style="list-style-type: none"> <i>-Барилгын гадна 28х16 метр хэмжээтэй төмөр хашааг зураг төсөвт батлагдсан стандартын дагуу хийж гүйцэтгэн бетон зуурмагаар бэхжүүлэн суурьлуулж будах. Явган хүний жижиг хаалга болон машин орох том хаалгыг тусад нь шийдэх</i> <i>-Гадна фасадыг дундаа хөөсөн дулаалгатай тод өнгийн металл сайдингаар брус модонд тогтоох ба дотор талд нь ус чийгнээс хамгаалсан зориулалтын материалыг хийж эрдэс хөвөнгөөр дулаална.</i> <i>-Сумын төвийн нэгдсэн дулаан хангамжийн системээс 32Ф-ийн хар трубагаар гадна монтажийг угсарч, зориулалтын хөөсөнцрөөр трубаг дулаалж булна. /гадна монтажийн эхлэл, төгсгөл дээр бөмбөлгөн хаалт хий авагч болон манометрийг хийх/</i> <i>-Дотор монтажийг 25Ф-ийн хар трубагаар угсарч, нэг бүр нь 100х60см хэмжээтэй 10 ширхэг иж бүрэн ширмэн радиаторыг цонх бүрийн доод хэсэгт суурьлуулах, будах</i> <i>-Гадна дотор хаалгыг барилгын одоо ашиглагдаж байгаа хаалганы гадна хэмжээг авч төмөр хаалгаар сольж суурьлуулах.</i> <i>-Дотох ханын гипсэн хавтанг өнгийг сэргээн эмульсдэх, муудсан хэсгийг солих</i> <i>-Шалны муудсан хэсгийг засварлан нөхөх /хулдаас/, коридорт паркетан шал хийх /захиалагчтай зөвшилцөх/</i> <i>-Дээврийн гадна хүрээг шинээр хайрцаглан хийж будах</i> <i>-Дээврийн төмрийн өнгийг сэргээн бүхэлд нь будах</i> <i>-Зураг төсөвт болон ажлын даалгаварт тусгагдснаас бусад жижиг гэмтэл, эвдрэлийг засварлах, солих</i>

	<ul style="list-style-type: none">-Коридорт гэрэл суулгах-Пийшин буулгаж хана өрөх-Хажуу самсааг төмөрлөх-Гэрэлтдэг хаяг хийх /АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ/ 260Х40 СМ
--	--

**ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙРЫГ
ТОХИЖУУЛАХ, ЗАСВАРЛАХ АЖЛЫН ТӨСӨВ**

1. Төсөв зохиох үндэслэл: Баян-Уул сумын “Ахуйн үйлчилгээний төв”-ийг тохижуулж, жижиг дунд бизнес эрхлэх орчныг сайжруулах.
2. Санхүүжилт: 2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр
3. Захиалагч: Баян-Уул сум. ЗДТГазар
4. Барилга байгууламжийн нэр, байршил: Баян-Уул сум 4-р багт. “Ахуйн үйлчилгээний төв”-ийн барилга
5. Архитектур төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал: Уг тохижуулахаар төлөвлөгдөж буй барилгыг шинээр төмөр хашаажуулах /22x22 метр/, гадна, дотор нийт 8 хаалгыг сайн чанарын төмөр хаалгаар солих, гадна ханыг ус, чийг тусгаарлагч хийж, эрдэс хөвөн дулаалгатай металл сайдинг /дундаа хөөстэй/-гаар өнгөлөх, төвлөрсөн дулаан хангамжаас халаалт татаж, өрөө тус бүрт радиатор суурьлуулах, бусад жижиг засваруудыг хийж гүйцэтгэх.

Гүйцэтгэх хугацаа: 2020 онд

АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАШААНЫ МАТЕРИАЛ

Д/д	Үндсэн хийц	Материал	Хэмжих нэгж	Хэмжээ

1	Хайс /1,2м/	Квадрат төмөр /20х30мм / 2мм зузаантай	М	475,2
2	Дай хөндөл /2,0м/	Квадрат төмөр /50х30мм / 2мм зузаантай	М	176
3	Шон /1,7м/	Квадрат төмөр /50х50мм / 3мм зузаантай	М	74,8
4	Бетон цутгамал	100 марктай бетон зуурмаг	М3	1,38
5	Будаг	Төмрийн будаг /118,8м ² талбайг будах/	Л	25
6	Хээ	Бэлдэц төмөр	Ш	45
7	Гагнуурын электрод		Кг	21к
8	Тасдагчийн ир		Ш	44
9	Тээвэр	Улаанбаатараас 600км		
10	Ажлын хөлс	Гагнуур, будаг, цемэнт		

ГАДНА ФАСАДЫГ ШИНЭЭР ХИЙХ МАТЕРИАЛ

д/д	Үндсэн хийц	Материал	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Гадна фасад	Металл сайдинг/дундаа хөөсөн дулаалгатай/ 3.8х0,38м	М2	141.12
2	Фасад тогтоох брус	Брус мод /0.05х0.05мм / урт нь 2.7метр	ш	50
3	Шруф /брус хананд тогтоох/	Хар шруф /10см/	ш	250
4	Шруф /фасад тогтоох/	Хар шруф /4см/	ш	882
5	Чийг тусгаарлагч	Полиетленэн /зориулалтын/	М2	141.12

6	Дулаалга	Эрдэс хөвөн /Изовер/	Боодол	10
7	Самсаа төмөр	Хэвт төмөр	М2	16
8	тээвэр	Улаанбаатараас 600км		
9	Ажлын хөлс			

ХААЛГА,БУСАД ЗАСВАРЫН МАТЕРИАЛЫН ҮНЭ,

д/д	Үндсэн хийц	Материал	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Гадна, дотор хаалга	Төмөр хаалга /бүргэд/	ш	8
2	Баллонтой хөөс		ш	14
3	Гипсэн хавтан	244x122 см	ш	3
4	Эмульс	Дотор ханын	л	18
5	Паркетан шал	Ус, чийгний хамгаалалттай	М2	14
6	Гэрэл	Нэмэх хэлбэртэй LED	ш	2
7	Цемент	М4.25	кг	115
8	Гэрлэн хаяг	“АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ” 240x40 см	М2	1,04

**ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИД ХОЛБОХОД ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛ,
АЖЛЫН ХӨЛС, ТЭЭВРИЙН ЗАРДАЛ**

д/д	Үндсэн хийц	Материал	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Радиатор	ширэм	секц	105
2	Труба /дотор монтаж/	Хар төмөр 25Ф	м	100
3	Труба /гадна/	Хар төмөр 32Ф	м	82
4	Хаалт	Бөмбөлгөн 25Ф	ш	2
5	Хаалт	Бөмбөлгөн 32Ф	ш	2
6	Холбогч хэрэгслүүд	Муфт, изгон, отвод, фа, хий авагч, сантехникийн олс	Иж бүрдэл	7

7	Гагнуурын электрод	Хар төмрийн	кг	5
8	Будаг	Төмрийн зориулалтын тосон	кг	14
9	Багс	3,5 мм	ш	4
10	Дулаалгын материал	32Ф зориулалтын хөөсөнцөр дулаалга	м	82

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Засаг даргын Тамгын газрын дарга Н. Бат-Амгалан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тооцоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн

ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> ⁴
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁵ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ___ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ___ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;

- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

